

Санхүүгийн хяналт шалгалт
хийсэн дүнгийн тухай

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын 2022 оны 05 сарын 09-ны өдрийн 1/12 тоот удирдамж аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албаны 2022 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн газрын 2020, 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, эрүүл мэндийн холбогдох хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

ХОЁР.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Л.Цэрэнбүтэд, А.Анхбаяр, дотоод аудитор П.Азхишиг нар 2022 оны 05 дүгээр сарын 11-ээс төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Эрүүл мэндийн төвийн 2020, 2021 оны үндсэн болон нэмэлт дансны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, олговор, тэтгэмж, шагнал урамшуулал, албан томилолтын бодолт, олголт, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, хүнсний бүтээгдэхүүн, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн байдал, шатахууны олголт, зарцуулалт, хэтрэлт хэмнэлт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг хамруулав.

ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Булган сумын 5-р багт байрлах 9011285 регистрийн дугаартай Эрүүл мэндийн газар нь аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудад хяналт үнэлгээ хийх, мэргэжил арга зүй, удирдлагаар хангахад оршино.

Эрүүл мэндийн газар нь 2021 оны 1 дүгээр сарын 14-ны өдрийн А/03 тоот Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар 1-р хавсралтаар тус газрын ажиллах орон тоог баталсан байна. Орон тооны хувьд газрын Эрүүл мэндийн газрын дарга 1, хэлтсийн дарга 3, мэргэжилтэн 17, голомтын ариутгал хариуцсан ажилтан 1, мэдээний сан хариуцсан ажилтан 1, нягтлан бодогч 1, жолооч 2, нярав 1, бичиг хэргийн ажилтан 1,

үйлчлэгч 1, жижүүр 3 гэсэн нийт 31 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

Эрүүл мэндийн газар бүтэц, зохион байгуулалт нь

- Нийгмийн эрүүл мэндийн төв нь дотороо халдварт өвчний тандалт, сэргийлэлтийн алба, Халдварт бус өвчний тандалт сэргийлэлт, эрүүл мэндийн үйлчилгээний алба

- Эмнэлэгийн тусламжийн хэлтэс

- Удирдлага, төлөвлөлт санхүү, мэдээллийн хэлтэс дотороо удирдлага мэдээллийн алба, санхүү үйлчилгээний алба гэсэн 3 хэлтэс 5 албатай үйл ажиллагаа явуулж байна.

Тус газрын 1 дүгээр гарын үсгийн 2020 оны 1 сарын 1-ний өдрөөс 2021 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд Эрүүл мэндийн газрын дарга С.Нарантуяа, хоёрдугаар гарын үсгийг 2020 оны 1 сарын 1-ний өдрөөс 2021 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд нягтлан бодогч Б.Энхтуяа нар зурж, төрийн санд бүртгэлийн 100040020001 дугаар, нэмэлт санхүүжилтийн 100040720401 дугаар данстайгаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн ба нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох “Acolous” программаар бүртгэж хөтөлсөн байна.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Төрийн Аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авсан байна.

Төрийн Аудитын газрын 2021 оны 2 сарын 25-ны өдрийн 01/34-БУЛ-2021СТА-ТШЗА0660248 тоот төлбөрийн актаар томилолтоор ажиллаагүй байхад томилолтын зардлыг олгож илүү олгосон томилолтын суутган тооцоолол хийлгүйгээр нийт 4468.0 мянган төгрөгийн албан томилолтыг хааж төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6, 18.1, 18.2, 20.2 дахь заалтуудыг зөрчсөн

Төрийн аудитын газрын 01/33-БУА-2021/СТА-ТШЗ төлбөрийн актаар Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/350, А/392 тоот тушаалыг зөрчин батлагдсан төсвийг хэтрүүлэн 1620.9 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д /Батлагдсан цалингийн сан, орон тоон ыхязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажилчдын балин хөлсийг тогтоох/ 42 дугаар зүйлийг 2.2 /Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах/ гэсэн заалт зөрчсөн

Аудитаар нийт 13714.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 6088.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 7625.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөнийг хугацаанд нь барагдуулж зөвлөмжийн хариуг хүргүүлсэн байна.

Төрийн аудитаар 2021 оны санхүүгийн тайланд нийцлийн аудит хийж зөрчилгүй дүгнэлт авсан байна.

Төрийн аудитын 01/20 АО670252 БУА-2022/147/НА/СТА-ТШЗ тоот төлбөрийн актаар тайлант хугацаанд ажилчин албан хаагчийг шагнаж урамшуулахдаа 661650 төгрөгийг илүү тооцон олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын нэг дүгээр хавсралтын 3.3-т “Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д

“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйд аймгийн Төрийн аудитын газрын 100040051005 тоот дансанд 2022 оны 06 дугаар сарын 10-ны дотор төвлөрүүлэхээр Эрүүл мэндийн газрын дарга

нягтлан бодогч нарт хариуцуулсаныг бүрэн барагдуулсан байна.

Төрийн аудитын 02/21 АО670252 БУА-2022/147/НА-СТА-ТШЗ тоот төлбөрийн актаар харьяалал бүхий сумын төвдөө ажиллаж буй найман эмчид нийт 822600 төгрөгийн томилолт олгосон нь Сангийн сайдын 2018 оны 301 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”-ыг 2-т “Албан тмилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, зам, хоног, уналгын зарлын төсвийг тухай бүр баталсны үндсэн дээр олгох, шаардлагагүй тохиолдолд төрийн албан хаагчид байрны зарал төсөвлөн олгохгүй байхыг төсөвт байгууллагын болон төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дарга нарт зөвлөсүгэй”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйд аймгийн Төрийн аудитын газрын 100040051005 тоот дансанд 2022 оны 06 дугаар сарын 10-ны дотор төвлөрүүлэхээр Эрүүл мэндийн газрын дарга нягтлан бодогч нарт хариуцуулсаныг бүрэн барагдуулсан байна.

Төрийн аудитын 02/42 АО670252 БУА-2022/147/НА-СТА-ТШЗ тоот албан шаардлагаар тооллогыг Эрүүл мэндийн газрын даргын А/102 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилогдон 12 дугаар сарын 14-нд тооллогыг хийж дууссан бөгөөд тооллого хийгдсэнээс хойш 16451000 төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж 792000 төгрөгийн үндсэн хөрөнгө зарцуулалт, бараа материалын хувьд 276401400 төгрөгийн орлого, 235705800 төгрөгийн зарцуулалт хөдөлгөөн хийгдсэн ч тооллогын дүн 12 дугаар сарын 31-ний үлдэгдэлээр тоологдсон нь тооллогыг үнэн зөв, бодитой хийгээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4 дэх “комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх”, гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу баримтжуулах, үр дүнг тооцох, архивын нэгж болгох, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллан албан шаардлагын хариуг аймгийн Төрийн аудитын газар 2022 оны 09 дугаар сарын 10-ны дотор төвлөрүүлэхээр Эрүүл мэндийн газрын дарга нягтлан бодогч нарт даалгасанг хугацаа болоогүй байна.

Төрийн аудитын 03/44 АО670252 БУА-2022/147/НА-СТА-ТШЗ тоот албан шаардлагаар Эрүүл мэндийн яамнаас ирсэн үндсэн хөрөнгийг орлогод авахгүй тушаалаар тооллогыг Эрүүл мэндийн газрын даргын А/102 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилогдон 12 дугаар сарын 14-нд тооллогыг хийж дууссан бөгөөд тооллого хийгдсэнээс хойш 16451000 төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж 792000 төгрөгийн үндсэн хөрөнгө зарцуулалт, бараа материалын хувьд 276401400 төгрөгийн орлого, 235705800 төгрөгийн зарцуулалт хөдөлгөөн хийгдсэн ч тооллогын дүн 12 дугаар сарын 31-ний үлдэгдэлээр тоологдсон нь тооллогыг үнэн зөв, бодитой хийгээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4 дэх “комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх”, гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу баримтжуулах, үр дүнг тооцох, архивын нэгж болгох, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллан албан шаардлагын хариуг аймгийн Төрийн

аудитын газар 2022 оны 09 дугаар сарын 10-ны дотор төвлөрүүлэхээр Эрүүл мэндийн газрын дарга нягтлан бодогч нарт даалгасан хугацаа болоогүй байна
Төрийн аудитын 04/45 АО670252 БУА-2022/147/НА-СТА-ТШЗ тоот албан шаардлагаар таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 42 удаагийн 3248716800 төгрөгийн орлого, 76 удаагийн 2450810400 төгрөгийн зарлагын гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ ... 6.4.5-д цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр ...” заалтыг бүрэн хэрэгжүүлж ажлаагүй байгаад Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасны дагуу мэдээллийг үнэн зөв мэдээлж, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллан албан шаардлагын биелэлтийг гаргаж Төрийн аудитын газар 2022 оны 09 дугаар сарын 10-ны дотор ирүүлэхийг Эрүүл мэндийн газрын дарга, нягтлан бодогч нарт даалгасан хугацаа болоогүй байна. ЗУРГАА. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2020 он: Эрүүл мэндийн газар нь шилэн дансны shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн дагуу 2020 онд төсөв, гүйцэтгэлийн цэсэнд 81 мэдээлэл оруулахаас, 64 мэдээллийг хугацаанд нь шивж 17 мэдээллийг хугацаа хоцроон, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт цэсэнд 39 мэдээллийг оруулахаас 37 мэдээллийг хугацаанд нь шивж, 2 мэдээллийг хугацаа хоцроон, бусад цэсэнд 61 мэдээлэл оруулахаас 60 мэдээллийг хугацаанд нь шивж 1 мэдээллийг хугацаа хоцроон мэдээллэсэн байна.

2021 он: Төсөв, гүйцэтгэлийн 75 мэдээлэл оруулахаас 72 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээлэл хугацаа хоцроож, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын 39 мэдээллийг оруулахаас 38 мэдээллийг хугацаанд нь бусад 61 мэдээлэл оруулахаас 59 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Мөн хугацаандаа оруулж байгаа 169 мэдээллийг үнэн зөв гүйцэд оруулж мэдээлсэн байна.

2022 оны 1-4-р сарын байдлаар төсөв, гүйцэтгэлийн 21 мэдээлэл оруулахаас 21 мэдээллийг хугацаанд нь, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын 12 мэдээллийг оруулахаас 12 мэдээллийг хугацаанд нь бусад 20 мэдээлэл оруулахаас 20 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

ДОЛОО. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Булган аймгийн Эрүүл мэндийн газрын 2020, 2021 оны төрийн сангийн харилцахын баримт, няравын бараа материалын баримт, жилийн эцсийн хөрөнгийн тооллогын бүртгэл, төсвийн шууд захирагчийн гаргасан А, Б тушаал, цалингийн карт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, санхүүгийн тайлан, төрийн аудитын байгууллага болон бусад байгууллагаас хийсэн шалгалтын материал зэрэг холбогдох бусад баримт материалуудад тулгуурлан газрын дарга С.Нарантуяа, нягтлан бодогч Б.Энхтуяа нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв

8.1.Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар: Эрүүл мэндийн газар нь 2020 онд төсвийн захриагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхэд 1505091.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, туслах үйл ажиллагааны орлого 4305.0 мянган төгрөг нийт 1509396.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1497526.5 мянган төгрөгийг зарцуулж, 11870.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 422966.2 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 422316.6 мянган төгрөгийг зарцуулж 649.5 мянган төгрөг, дотоод албан томилолтыг 4125.0 мянган төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 4104.2 мянган төгрөгийг зарцуулж 20.8 мянган төгрөг, эм, эмнэлгийн хэрэгсэлийн зардлыг 191455.7 мянган төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 191365.0 мянган төгрөгийг зарцуулж 90.7 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөхшигтгэлийг 257100.2 мянган төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 252949.1 мянган төгрөгийг зарцуулж 4151.1 мянган төгрөгийн зардлыг хэмнэсэн байна.

2021 он: Төсвийн санхүүжилтээр 1836559.1 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив 170007.8 мянган төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 55285.2 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 1015508.7 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого 13066.0 мянган төгрөг нийт 309791.6 мянган төгрөг бүрдүүлсэн байна.

Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 487925.3 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 62116.0 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 3384.2 мянган төгрөг, түлш, халаалтын зардалд 40326.7 мянган төгрөг, цэвэр, бохир усны зардалд 2809.5 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 7138.0 мянган төгрөг, тээвэр, шатахууны зардалд 49087.4 мянган төгрөг, шуудан холбоо, интернетийн төлбөрт 2620.2 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалд 2000.0 мянган төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд 1567.9 мянган төгрөг, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд 39115.2 мянган төгрөг, нормын хувцас, зөөлөн эдлэлд 853.6 мянган төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгсэлд 902.8 мянган төгрөг, урсгал зардалд 7831.1 мянган төгрөг, дотоод албан томилолт 53128.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 12664.7 мянган төгрөг, даатгалын үйлчилгээнд 1990.6 мянган төгрөг, тээврийн хэрэгсэлийн татварт 991.6 мянган төгрөг, мэдээлэл, технологийн үйлчилгээнд 4800.0 мянган төгрөг, газрын төлбөрт 24.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 23106.2 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийхэд 102658.6 мянган төгрөг, ажил олгогчоос бусад тэтгэмж, урамшуулалд 934.7 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжид 291321.1 мянган төгрөг, биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал 17000.0 мянган төгрөг нийт урсгал үйл ажиллагаанд 3085651.7 мянган төгрөгийг зарцуулж, 12139.9 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

Зарцуулалтын талаар

2020 он: Эрүүл мэндийн газрын даргын 1 сарын 07-ны өдрийн А/04 тоот тушаалаар “Эрүүл идэвхитэй амьдралын төлөө хамтдаа” өдөрлөг арга хэмжээг зохион байгуулахад 310.0 мянган төгрөг, 2 сарын 20-ны өдрийн А/16 тоот тушаалаар шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг өргөжүүлэх ажлыг зохион байгуулахад сурталчилгааны материал хэвлүүлэхэд 1250.0 мянган төгрөг, 3 сарын 18-ны өдрийн А/28 тоот тушаалаар коронавирусын халдвараас урьдчилан сэргийлж, төрийн албан хаагч дын нийгмийн баталгааг хангах, ажлын байранд дархлаа дэмжих, халдваргүйжүүлэх бэлдмэл худалдан авахад 373.0 мянган төгрөг, 4 сарын 16-ны өдрийн А/40 тоот тушаалаар Орон нутагт зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хязгаарласантай холбогдуулан Булган сумаас орох, гарах хөдөлгөөнийг зохицуулах хяналтын цэгээр орж, гарч байгаа иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэхэд 372.5 мянган төгрөг, 4 сарын 15-ны өдрийн А/39 тоот тушаалаар шинэ коронавирусын халдвараас урьдчилан

сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааны самбар, гарын авлага олшруулахад 1166.0 мянган төгрөг, 5 сарын 15-ны өдрийн А/52 тоот тушаалаар коронавирусын халдвараас урьдчилан сэргийлж, төрийн албан хаагчдын ажлын байранд дархлаа дэмжих бэлдмэл олгох, гамшигаас хамгаалах команд штабын дадлага сургуулийн үед бэлэн байдлыг хангахад шаардагдах санхүүжилт 637.5 мянган төгрөг, 5 сарын 15-ны өдрийн А/53 тоот тушаалаар Сувилагч, эх баригчдын үйл ажиллагааг алдаршуулах. Сурталчлах “Миний мэргэжил” сайхан нэвтрүүлгийг “Сайхан монгол” телевизтэй хамтран зохион байгуулахад 1000.0 мянган төгрөг, 5 сарын 27-ны өдрийн А/56 тоот тушаалаар “Сүрьеэгийн сорил тавих техник арга зүй сургалтыг зохион байгуулахад 758.8 мянган төгрөг, 6 сарын 12-ны өдрийн А/62 тоот тушаалаар архины шууд болон дам хамааралтай иргэдэд чиглэсэн сэтгэл зүйн болон хордлого тайлах эмчилгээнд 512.9 мянган төгрөг, 08 сарын 14-ний өдрийн Эрүүл мэндийн газрын даргын А/80 тоот тушаалаар “Эх баригч нарын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх нь” сургалт зохион байгуулахад 488.3 мянган төгрөг, 08 сарын 14-ний өдрийн Эрүүл мэндийн газрын даргын А/81 тоот тушаалаар “Ахлах сувилагч нарын удирдлага манлайлалыг нэмэгдүүлэх нь” сургалт зохион байгуулахад 369.9 мянган төгрөг, 08 сарын 14-ний А/82 тоот газрын даргын тушаалаар Аймгийн Эрүүл мэндийн салбарын 2019 оны “Шилдэг байгууллага”, “Шилдэг төрийн албан хаагчид”-ыг шалгаруулахад 1072.0 мянган төгрөг, 9 сарын 29-ний өдрийн А/91 тоот газрын даргын тушаалаар “Ахмадын өдөрлөг, витаминжуулалтын арга хэмжээ зохион байгуулахад зориулан 1167.8 мянган төгрөг, 9 сарын 22-ны өдрийн Эрүүл мэндийн газрын даргын А/89 тоот тушаалаар “Амилуулах суурь тусламжийг үзүүлэхэд жолооч нарын ур чадварыг нэмэгдүүлэх нь” сургалт зохион байгуулахад 482.5 мянган төгрөг, 10 сарын 26-ны А/94 тоот газрын даргын тушаалаар “Хүүхэд өсвөр үеийнхэнд зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэг” сэдэвт сургалтыг зохион байгуулахад зориулан 181.0 мянган төгрөг, 11 сарын 17-ны А/107 тоот тушаалаар “Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, эмнэл зүйн тусламж үйлчилгээ” сургалтыг Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагууд, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш ажилчдад зохион байгуулахад 625.3 мянган төгрөг, 11 сарын 29-ний өдрийн А/110 тоот тушаалаар Коронавирус халдвар кластер хэлбэрээр гарч байгаатай холбогдуулан мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг өргөжүүлэн зохион байгуулах ажлын хүрээнд зөвлөмжийг шинэлэг ойлгомжтой хэлбэрээр бэлтгэн хэвлүүлэх сум өрхийн Эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, гэрийн ажиглалтанд байгаа иргэдэд түгээх үйл ажиллагаа шуурхай зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллахад шаардагдах зардалд 1050.0 мянган төгрөг, 12 сарын 10-ны өдрийн Газрын даргын А/116 тоот тушаалаар Тохиолдлын удирдлагын тотолцооны мэргэжлийн багийн гишүүдийг чадавхижуулах сургалтыг зохион байгуулахад 1489.0 мянган төгрөг, 12 сарын 22-ны өдрийн А/126 тоот газрын даргын тушаалаар “Коронавирусын халдвараас сэргийлэх, тандалт, халдаргүйжүүлэлт хийх арга зүй” сургалтыг зохион байгуулахад 231.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тусламж, урамшууллын талаар

Эрүүл мэндийн газрын даргын 05 сарын 12-ны өдрийн Б/27 тоот тушаалаар Хөрөнгө оруулалт, эм эмнэлгийн хэрэгслийн хангамж, худалдан авалт хариуцсан мэргэжилтэн Д.Батдэлгэрт хүүхэдтэй болсон тул 50.0 мянган төгрөг, 5 сарын 8-ны өдрийн Б/25 тоот тушаалаар эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, салбарын санхүүгийн бүртгэл мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Мягмарсүрэнгийн хүү цусны хорт хавдар өвчний улмаас удаан хугацаагаар

эмчлүүлж байгаа байдлыг харгалзан 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж 768.0 мянган төгрөг, 6 сарын 23-ны өдрийн Б/33 тоот тушаалаар архив бичиг хэргийн ажилтан Э.Ариунтунгалагт байшингаа сэргээн засварлахад зориулж 100.0 мянган төгрөгийн, 9 сарын 16-ны өдрийн Б/42 тоот тушаалаар Мэдээллийн технологи, телемедицин хариуцсан мэргэжилтэн П.Отгонбаярт 150.0 мянган төгрөгийн тусламж, 6 сарын 15-ны өдрийн Б/28 тоот аймгийн Засаг даргын захирамжаар Эрүүл мэндийн газрын дарга С.Нарантуяагийн аав нас барсан тул 200.0 мянган төгрөг, 11 сарын 24-ний өдрийн Б/51 тоот тушаалаар жолооч Н.Отгонбямбад буцалтгүй тусламж 50.0 мянган төгрөг, 12 сарын 10-ны өдрийн Б/55 тоот газрын даргын тушаалаар тус газрын хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Б.Гантулга нь хөлний үений мэс засалд орж удаан хугацаагаар эмчлүүлэх шаардлагатай болсон тул 1 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх тэтгэмж 754.8 мянган төгрөгийг олгосон байна.

Эрүүл мэндийн газрын даргын 6 сарын 29-ны өдрийн А/71 тоот тушаалаар 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн тайлан болон нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн чанар үр дүнгээр хангалттай үнэлэгдсэн тул эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, салбарын санхүүгийн бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, нягтлан бодогч, нярав нарт 2 сарын үндсэн цалин 4466.4 мянган төгрөг, 6 сарын 17-ны өдрийн А/66 тоот газрын даргын тушаалаар Эрүүл мэндийн салбарын статистик тайлан мэдээний 2019 оны ажлын гүйцэтгэлээр хангалттай үнэлэгдсэн тул Статистик бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн Урангаваа, эрүүл мэндийн мэдээний сан хариуцсан ажилтан С.Батхишиг нарт үндсэн цалингийн 40 хувиар тооцон 2069.1 мянган төгрөг, 8 сарын 12-ны өдрийн А/79 тоот газрын даргын тушаалаар 2020 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн тайлан болон нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн чанар үр дүнгээр хангалттай үнэлэгдсэн тул эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, салбарын санхүүгийн бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, нягтлан бодогч, нярав нарт 2 сарын үндсэн цалин 4466.3 мянган төгрөг, 12 сарын 10-ны өдрийн Б/56 тоот тушаалаар эрүүл мэндийн боловсрол, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Гүндэгмаад Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх хүн амд гарын авлага тараах материалыг шинэлэг хэлбэрээр хийж байгууллагын эдийн засагт хэмнэлт гарган ажилласан тул 1,2 сарын албан тушаалын үндсэн цалин 854.8 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

2021 он Эрүүл мэндийн газрын даргын Б/18 тоот тушаалаар 2021 оны 1 дүгээр улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулалд 11 үйлчилгээний ажилчидад 40 %-аар 2748.3 мянган төгрөг, Б/34 тоот тушаалаар короновируст халдварын үе ажилласан, мөнгөн тусламж 29 албан хаагчидад 29000.0 мянган төгрөг, Б/39 тоот тушаалаар ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн хагас жилийн үнэлгээгээр мөнгөн урамшуулал 17 мэргэжилтэнд 40-80%, 10 үйлчилгээний ажиллагсадад 20-40%-аар 7269.5 мянган төгрөг, Б/40 тоот тушаалаар санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн болон нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг чанар, үр дүнгийн 2021 оны хагас жилийн үнэлгээгээр хангалттай сайн буюу А дүгнэгдсэн эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, салбарын санхүүгийн бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн 2 сарын үндсэн цалин 1706.8 мянган төгрөг, нягтлан бодогчид 2 сарын үндсэн цалин 2400.0 мянган төгрөг, няравт 1 сарын цалин 547.5 мянган төгрөг, Б/43 тоот тушаалаар короновируст халдварын үед ажиллаж байгаа, мөнгөн тусламж үзүүлэх төрийн албан хаагч 32 албан хаагчидад 12700.0 мянган төгрөг, Б/55 тоот тушаалаар Эрүүл мэндийн салбарын статистик тайлан мэдээний 2020 оны ажлын гүйцэтгэлээр А үнэлгээтэй дүгнэгдсэн Статистик бүртгэл мэдээлэл хариуцсан

мэргэжилтэн, эрүүл мэндийн мэдээний сан хариуцсан бага эмч нарт 40%-аар 3 сарын хугацаанд 2069.1 мянган төгрөг, Б/59 тоот тушаалаар 3 дугаар улирлын урамшуулалд 10 үйлчилгээний ажиллагсадад 20-40%-аар 7240.8 мянган төгрөг, Б/61 тоот тушаалаар коронавируст халдварын үед ажиллаж байгаа, 4 эмнэлгийн ажиллагсадад 4000.0 мянган төгрөг, Б/67 тоот тушаалаар коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн эрүүл мэндийн шуурхай албаны шуурхай штабын байранд хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэж илүү цагаар ажилласан төрийн албан хаагчид 2784.2 мянган төгрөг, Б/73 тоот тушаалаар ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн 4 дүгээр улирлын урамшуулалд 19 мэргэжилтэнд 80%-аар, үйлчилгээний 12 ажиллагсадад 40%-аар 20931.6 мянган төгрөг нийт 93397.5 мянган төгрөг олгосон байна.

Эм,эмнэлгийн хэрэгслийн санхүүжилтийн талаар

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 2 сарын 18-ны өдрийн А/13 тоот тушаалаар 2020 оны батлагдсан төсвөөс орон нутгийн тусгай зориулалтын шилжүүлгийн Эрүүл мэндийн байгууллагуудад олгох хоёрдугаар сарын эм эмнэлгийн хэрэгслийн санхүүжилтийн хуваарыг батлан 24500.0 мянган төгрөгийг, 3 сарын 09-ний өдрийн Эрүүл мэндийн газрын даргын А/23 тоот тушаалаар Эрүүл мэндийн байгууллагуудад олгох хоёрдугаар сарын эм эмнэлгийн хэрэгслийн санхүүжилтийн хуваарыг батлан 14850.0 мянган төгрөгийг, 4 сарын 06-ны өдрийн Эрүүл мэндийн газрын даргын А/37 тоот тушаалаар Эрүүл мэндийн байгууллагуудад олгох хоёрдугаар сарын эм эмнэлгийн хэрэгслийн санхүүжилтийн хуваарыг батлан 15400.0 мянган төгрөгийг, 5 сарын 13-ны өдрийн Эрүүл мэндийн газрын даргын А/51 тоот тушаалаар Эрүүл мэндийн байгууллагуудад олгох хоёрдугаар сарын эм эмнэлгийн хэрэгслийн санхүүжилтийн хуваарыг батлан 13550.0 мянган төгрөгийг, 6 сарын 25-ны өдрийн Эрүүл мэндийн газрын даргын А/70 тоот тушаалаар Эрүүл мэндийн байгууллагуудад олгох хоёрдугаар сарын эм эмнэлгийн хэрэгслийн санхүүжилтийн хуваарыг батлан 14300.0 мянган төгрөгийг мөн 6 сарын 11-ний өдрийн А/60 тоот тушаалаар 11400.0 мянган төгрөгийг, 7 сарын 20-ны өдрийн Эрүүл мэндийн газрын даргын А/74 тоот тушаалаар Эрүүл мэндийн байгууллагуудад олгох долоодугаар сарын эм эмнэлгийн хэрэгслийн санхүүжилтийн хуваарыг батлан 10275.0 мянган төгрөгийг, 8 сарын 10-ны өдрийн Эрүүл мэндийн газрын даргын А/77 тоот тушаалаар Эрүүл мэндийн байгууллагуудад олгох наймдугаар сарын эм эмнэлгийн хэрэгслийн санхүүжилтийн хуваарыг батлан 9925.0 мянган төгрөгийг, 9 сарын 10-ны өдрийн Эрүүл мэндийн газрын даргын А/86 тоот тушаалаар Эрүүл мэндийн байгууллагуудад олгох есдүгээр сарын эм эмнэлгийн хэрэгслийн санхүүжилтийн хуваарыг батлан 11800.0 мянган төгрөгийг, 10 сарын 13-ны өдрийн Эрүүл мэндийн газрын даргын А/98 тоот тушаалаар Эрүүл мэндийн байгууллагуудад олгох аравдугаар сарын эм эмнэлгийн хэрэгслийн санхүүжилтийн хуваарыг батлан 13050.0 мянган төгрөгийг, 11 сарын 09-ний өдрийн Эрүүл мэндийн газрын даргын А/103 тоот тушаалаар Эрүүл мэндийн байгууллагуудад олгох аравдугаар сарын эм эмнэлгийн хэрэгслийн санхүүжилтийн хуваарыг батлан 12925.0 мянган төгрөгийг, 12 сарын 04-ний өдрийн Эрүүл мэндийн газрын даргын А/112 тоот тушаалаар Эрүүл мэндийн байгууллагуудад олгох арванхоёр дугаар сарын эм эмнэлгийн хэрэгслийн санхүүжилтийн хуваарыг батлан 11950.0 мянган төгрөг, 12 сарын 21-ний өдрийн Эрүүл мэндийн газрын даргын А/123 тоот тушаалаар Эрүүл мэндийн байгууллагуудад олгох арванхоёр дугаар сарын эм эмнэлгийн хэрэгслийн санхүүжилтийн хуваарыг батлан 22500.0 мянган төгрөгийг мөн өдрийн А/125 тушаалаар 6678.4 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Мөнгөн тэтгэмжийн талаар

Эрүүл мэндийн газрын даргын 2 сарын 17-ны өдрийн Б/14 тоот тушаалаар өндөр насны тэтгэвэрт гарсан Гурванбулаг сумын ЭМТ-ийн ахлах сувилагч И.Оюунчимэгт тэтгэмж 22441.7 мянган төгрөг, 05 сарын 5-ны өдрийн Б/24 тоот тушаалаар Баян-Агт сумын ЭМТ-ийн ээлжийн сувилагч Т.Чанцалд тэтгэмж 21515.8 мянган төгрөг, 05 сарын 12-ны өдрийн А/50 тоот тушаалаар өндөр насны тэтгэвэрт гарсан Эрүүл мэндийн газрын жижүүр М.Пүрэвсүрэнд тэтгэмж 12242.0 мянган төгрөг, Бугат сумын ЭМТ-ийн сувилагч Л.Цэрэндэжидэд тэтгэмж 17676.0 мянган төгрөг, 9 сарын 01-ний өдрийн А/85 тоот тушаалаар өндөр насны тэтгэвэрт гарсан Гурванбулаг сумын ЭМТ-ийн арга зүйч бага эмч С.Буяндэлгэрт тэтгэмж 22953.1 мянган төгрөг, багийн бага эмч Ц.Нарангэрэлд тэтгэмж 20337.6 мянган төгрөг, Баян-Агт сумын ЭМТ-ийн арга зүйч бага эмч Б.Должинсүрэнд тэтгэмж 23571.1 мянган төгрөг, 10 сарын 13-ны өдрийн А/97 тоот тушаалаар өндөр насны тэтгэвэрт гарсан Бугат сумын ЭМТ-ийн багийн бага эмч С.Мягмарсүрэнд тэтгэмж 20380.3 мянган төгрөг, 09 сарын 22-ны өдрийн А/90 тоот тушаалаар өндөр насны тэтгэвэрт гарсан Хялганат тосгоны ЭМТ-ийн их эмч Д.Туулд тэтгэмж 17843.4 мянган төгрөг, 11 сарын 25-ны өдрийн А/108 тоот тушаалаар өндөр насны тэтгэвэрт гарсан Бугат сумын ЭМТ-ийн үйлчлэгч О.Хишигсүрэнд тэтгэмж 14594.6 мянган төгрөг, Нэгдсэн эмнэлгийн лаборант Б.Алтанцэцэгт тэтгэмж 23195.2 мянган төгрөг, Нэгдсэн эмнэлгийн сувилагч Д.Оюунцэцэгт тэтгэмж 24894.0 мянган төгрөг, нэгдсэн эмнэлгийн үйлчлэгч Р.Бүрэнжаргалд тэтгэмж 17626.1 мянган төгрөг, Хишиг-Өндөр сумын ЭМТ-ийн сувилагч Д.Оюунчимэгт тэтгэмж 22374.3 мянган төгрөг, Дашинчилэн сумын ЭМТ-ийн статистикч бага эмч Ц.Ариунбуянд тэтгэмж 18856.9 мянган төгрөг, 12 сарын 16-ны өдрийн А/120 тоот тушаалаар өндөр насны тэтгэвэрт гарсан Нэгдсэн эмнэлгийн сувилагч Н.Буянхишигт тэтгэмж 24849.0 мянган төгрөг, Нэгдсэн эмнэлгийн сувилагч Б.Туяад тэтгэмж 25167.2 мянган төгрөг, Нэгдсэн эмнэлгийн автоклавчин Н.Оюунцэцэгт тэтгэмж 23321.2 мянган төгрөг, 12 сарын 21-ний өдрийн Б/57 тоот тушаалаар өндөр насны тэтгэвэрт гарсан Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн үйлчлэгч Д.Жаргалсайханд тэтгэмж 15867.8 мянган төгрөг нийт 20 ажилтанд 399528.8 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

2020 оны 03 сарын 30-ний өдрийн А/32 тоот газрын даргын тушаалаар “Эрүүл мэндийн тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь /Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэгт тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд гурван жил тутамд нэг удаа зургаан сарын, аймаг дахь төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас нь олгоно /заалтын дагуу мөнгөн тэтгэмж олгох 18 төрийн албан хаагчид 72179.1 мянган төгрөг, 5 сарын 27-ны өдрийн А/57 тоот газрын даргын тушаалаар 10 албан хаагчид 42052.7 мянган төгрөг, 6 сарын 22-ны өдрийн А/69 тоот газрын даргын тушаалаар 10 албан хаагчид 35251.2 мянган төгрөг, 8 сарын 12-ны өдрийн А/78 тоот газрын даргын тушаалаар 14 албан хаагчид 54874.3 мянган төгрөг, 11 сарын 25-ны өдрийн А/108 тоот тушаалаар 147414.6 мянган төгрөг, 12 сарын 16-ны өдрийн А/120 тоот тушаалаар 92369.5 мянган төгрөгийг тус тус олгосон байна.

2021 он: Б/20 тоот тушаалаар Хишиг-Өндөр сумын эрүүл мэндийн төвийн үйлчлэгч С.Дунгармаад тэтгэмжид 16436.0 мянган төгрөг, Б/28 тоот тушаалаар Хангал сумын ЭМТ-ийн сувилагч, Бугат сумын ЭМТ-ийнн үйлчлэгч, Эрүүл мэндийн газрын

нягтлан бодогч нарт тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж 67459.1 мянган төгрөг, аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн сувилагчид тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж 25530.4 мянган төгрөг, Б/36 тоот тушаалаар эрүүл мэндийн тухай хуулийн холбогдох заалтаар 6 сарын цалинтай тэнцэх 1 удаагийн мөнгөн тэтгэмж 61 эмч, эмнэлгийн ажилтанд 284308.4 мянган төгрөг, Б/42 тоот тушаалаар тэтгэвэрт гарсан Хялганат тосгоны ЭМТ-ийн сувилагч, Сэлэнгэ сумын ЭМТ-ийн жолооч нарт 31969.2 мянган төгрөг, Б/53 тоот тушаалаар эрүүл мэндийн тухай хуулийн холбогдох заалтаар 6 сарын цалинтай тэнцэх 1 удаагийн мөнгөн тэтгэмж 33 эмч, эмнэлгийн ажиллагсадад 152182.7 мянган төгрөг, Б/56 тоот тушаалаар эрүүл мэндийн тухай хуулийн холбогдох заалтаар 6 сарын цалинтай тэнцэх 1 удаагийн мөнгөн тэтгэмж 8 эмч, эмнэлгийн ажиллагсадад 30391.4 мянган төгрөг, Б/58 тоот тушаалаар аймгийн нэгдсэн эмнэлгийн үйлчлэгчид 18639.5 мянган төгрөг нийт 626916.7 мянган төгрөг олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын талаар: Тус газар нь 2020 онд өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 4305.0 мянган төгрөгөөр батлагдсанаас, гүйцэтгэлээр 8993.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн талаар: 2020 он: Эрүүл мэндийн газрын нэмэлт санхүүжилтийн дансанд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 9520.0 мянган төгрөг, “Булган нутгийн хөгжлийн сан”-гаас хандив тусламж 4000.0 мянган төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 22025.2 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 24981.0 мянган төгрөг, үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 175.0 мянган төгрөг, давсан орлогоос 3672.5 мянган төгрөг нийт 64373.7 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Зарцуулалт: Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 02 сарын 19-ний өдрийн А/15 тоот тушаалаар “Шинэ коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэгчээр “Булган Монос” ХХК-ийг шалгаруулан 20080.0 мянган төгрөг, 3 сарын 10-ны А/24 тоот “Сүрьеэгийн сорьц тээвэрлэсэн замын зардал олгох тухай” тушаалаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Сүрьеэгийн диспансер”-аас өвчний дахилт, эмчилгээний хяналтын цэрний сорьц тээвэрлэсэн замын зардалд 212.0 мянган төгрөг, 3 сарын 31-ний өдрийн А/33 тоот тушаалаар цэрний сорьц тээвэрлэсний зардалд 66.0 мянган төгрөг, 6 сарын 16-нд цэрний сорьц тээвэрлэсний зардалд 108.0 мянган төгрөг, 11 сарын 04-ний өдрийн А/101 тоот тушаалаар сорьц тээвэрлэсний замын зардалд 36.0 мянган төгрөг, аймгийн онцгой комиссын даргын 2020 оны 4 сарын 23-ний өдрийн 22 тоот тушаалаар аймгийн Онцгой комиссын 4 сарын 22-ны өдрийн 16 дугаар хуралдааны шийдвэрээр Гамшгаас хамгаалах сангаас Эрүүл мэндийн газарт урьдчилан сэргийлэх, халдваргүйтгэлийн бодисын нөөц бүрдүүлэхэд 1800.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Үүнийг СОБЦ ХХК-иас жавельон худалдан авахад 1530.0 мянган төгрөг, нэг удаагийн бээлий худалдан авахад 73.5 мянган төгрөг, Монос булган ХХК-иас спирт денатурат 70%-ийн 5 л гадуур хэрэглэх уусмал худалдан авахад 106.5 мянган төгрөг, жавельон /шахмал/ худалдан авахад 90.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 4 сарын 23-ны өдрийн А/259 тоот тушаалаар “Коронавирус (COVID-19) халдварын сэргийлэлт хяналт, эмнэл зүйн менежмент” сургалтыг зохион байгуулахад ДЭМБ-аас байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжиж ирсэн 9520.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: багшийн хөлс 1760.0 мянган төгрөг, туслахын хөлс 220.0 мянган төгрөг, зохион байгуулагчийн хөлс 360.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардал 716.0 мянган төгрөг, хоолны зардал 468.0 мянган төгрөг, цайны зардал 3902.0 мянган төгрөг, бичиг

хэргийн зардал 558.0 мянган төгрөг, дотоод албан томилолт 1536.0 мянган төгрөг, аймгийн онцгой комиссын даргын 2020 оны 5 сарын 20-ний өдрийн 25 тоот тушаалаар аймгийн Онцгой комиссын 5 сарын 05-ны өдрийн 17 дугаар хуралдааны шийдвэрээр гамшгаас хамгаалах сангаас “Маскаа зүүцгээе” аяны хүрээнд мэдээллийн хулдаасан хэвлэл бэлтгэхэд 145.2 мянган төгрөг, 2020 оны 6 сарын 17-ны өдрийн А/67 тоот тушаалаар төрийн албан хаагч нарт урамшуулал олгосон байна. Үүнд хүүхэд төрүүлсэн 3 албан хаагч нарт 150.0 мянган төгрөг, өөрийн эзэмшлийн байшингаа сэргээн засварласан 1албан хаагчид 100.0 мянган төгрөг, 2 албан хаагчид үндсэн цалингийн 50%-аар мөнгөн тэтгэмж 667.4 мянган төгрөг, хадам аав нь нас барсан 1 албан хаагчид 200.0 мянган төгрөг, нас барсан 2 ахмад настны гэр бүлд 200.0 мянган төгрөг, зайнаас халуун хэмжигч худалдан авахад 660.0 мянган төгрөг, батарей худалдан авахад 6.0 мянган төгрөг, шатахууны зардалд 693.3 мянган төгрөг, 08 сарын 18-ны өдрийн А/83 тоот тушаалаар “Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг өргөжүүлэх, орон нутагт зохион байгуулах ажлын хүрээнд сургалт сурталчилгааны материал коронавирус халдвараас урьдчилан сэргийлэх зурагт хуудас видео, шторик, анимейшн, подкаст, CD олшруулах, эх бэлтгэх, амны хаалт зүүх зөвлөмж хэвлүүлэхэд 2700.0 мянган төгрөг, 10 сарын 06-ны өдрийн А/95 тоот тушаалаар “Коронавируст халдварын үед эх барихын тусламж үйлчилгээнд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах нь” сургалтыг зохион байгуулахад 540.0 мянган төгрөг, 11 сарын 6-ны өдрийн А/102 тоот тушаалаар “Сүрьеэ илрүүлэх идэвхтэй үзлэг”-ийг Сайхан, Баян-Агт, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Хялганат, Бүрэгхангай, Дашинчилэн сумдад зохион байгуулахад шатахууны зардал 1303.2 мянган төгрөг, үзлэг зохион байгуулж, сорьц цуглуулах мэргэжилтнүүдийн томилолтын зардалд 12456.0 мянган төгрөг 12 сарын 03-ны өдрийн А/111 тоот тушаалаар “Коронавирусын халдварын хоёр дахь давлагаа Монгол улсад кластер хэлбэрээр гарч, улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан “Булган нутгийн хөгжлийн сан”-гаас хандивласан 4000.0 мянган төгрөгийг нэн шаардлагатай зардлуудад холбогдох хууль, дүрэм журмыг баримтлан зарцуулахаар шийдвэрлэсэн байна. Үүнээс: Тусгаарлалтанд байгаа иргэдийн хоолны зардалд “Элбэг эд ХХК”-д 1764.6 мянган төгрөг, буудлын зардалд “Жаргант буудал”-д 416.0 мянган төгрөг, Теккрафт ХХК-иас гар ариутгах төхөөрөмж худалдан авахад 240.0 мянган төгрөг, 12 сарын 10-ны өдрийн А/115 тоот тушаалаар Булган эм хангамж ХХК-иас витамин худалдан авахад 731.5 мянган төгрөг, Тунамал өгөөж ХХК-иас бараа бүтээгдэхүүн худалдан авахад 260.0 төгрөг, 12 сарын 10-ны өдрийн А/117 тоот тушаалаар голомттой бүс нутгаас ирсэн иргэдээс утсаар тандалт асуумж авч байгаа тандалт судалгааны багийн гишүүдийн ярианы зардалд 438.8 мянган төгрөг, Булган Анар ХХК-иас ариутгалын сав худалдан авахад 60.0 мянган төгрөг, Мобиком корпораци ХХК-иас нэгж худалдан авахад 89.0 мянган төгрөг, 12 сарын 21-ний А/124 тоот тушаалаар “Эрүүл ахуйн аян”-ыг орон нутагтаа амжилттай зохион байгуулан, шилдэг сайн туршлага түгээн дэлгэрүүлж улсын хэмжээнд 1-р байр эзэлсэн 4 төрийн албан хаагчдын урамшуулалд 400.0 мянган төгрөг, шатахууны зардалд 654.4 мянган төгрөг, Сайхан монгол ЭИАК НҮТББ-д шторк сурталчилгааны үнэ 300.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Эрүүл мэндийн газрын даргын 12 сарын 18-ны өдрийн А/121 тоот тушаалаар Коронавируст халдвартай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Эрүүл мэндийн 20 байгууллагад ажиллагсадад 4000.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

2021 он: Эрүүл мэндийн яамнаас сайдын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496 тоот тушаалаар Коронавируст халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын албан хаагчдыг урамшуулах зорилгоор олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 691000.0 мянган төгрөг, мөн сайдын 2021 оны 09 дугаар сарын 17-ны өдрийн А/585 тоот тушаалаар Коронавируст халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын албан хаагчдыг урамшуулах зорилгоор олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 244800.0 мянган төгрөг нийт 935800.0 мянган төгрөг, ЭМ-ийн санхүүжилтийн шинэчлэл, стратегийн худалдан авалт, эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэх зориулалтаар 3725.0 мянган төгрөг, ХӨСҮТ-ээс томуугийн 9-р зөвлөгөөний дэмжлэг хяналтын зардал санхүүжүүлэхэд 646.0 мянган төгрөг, эрүүл мэндийн ажилтануудад илүү цагийн хөлс, вакцин тээврийн зардал, нөхөн дархлаажуулалтын заралд 75256.5 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/125 тоот захирамжаар Коронавируст халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай авах зорилгоор Шуурхай штабын Эрүүл мэндийн албаны тандалтын багийн шуудан холбооны зардалд 315.0 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс, Гамшгаас хамгаалах сангаас Онцгой комиссын даргын 2021 оны 03 дугаар сарын 30-ны 10 тоот тушаалаар тус аймгийн Сэлэнгэ суманд Коронавируст халдварт өвчин батлагдсан, цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, илрүүлэх хариу арга хэмжээ авах, нөөц бүрдүүлэхэд эрүүл мэндийн байгууллагад түргэвчилсэн оноглуур худалдан авахад 15000.0 мянган төгрөг, Байгаль хамгаалах сангаас аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/521 тоот захирамжаар орон нутгийн иргэд, газар тариалан, уул уурхайн ажилтнуудыг Коронавируст халдварын эсрэг нэгдүгээр тунгийн вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах 9370.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/311 тоот захирамжаар аймгийн баяр наадмыг зохион байгуулах зардлаас Коронавируст халдварын бэлэн байдлыг хангах зорилгоор аймгийн Нэгдсэн эмнэлэгт нэн шаагдлагатай байгаа тоног төхөөрөмжөөр хангах зорилгоор 30600.2 мянган төгрөг, Монголын сумын эмч мэргэжилтэнүүдийн холбооноос 26913.7 мянган төгрөг нийт 1245072.6 мянган төгрөг орж ирсэн байна.

Зарцуулалт: Аймгийн 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/125 тоот захирамжаар коронавируст халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай авах зорилгоор Шуурхай штабын Эрүүл мэндийн албаны тандалтын багийн шуудан холбооны зардалд 315.0 мянган төгрөг зарцуулахаар шийдвэрлэж эрүүл мэндийн газрын мэргэжилтэн болон өрхийн эмнэлгийн эмч 21 хүнд тус бүр 15.0 мянган төгрөгийн нэгжний мөнгө өгсөн байна.

Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн А/26 тоот тушаалаар “Сүрьеэ илрүүлэх идэвхтэй үзлэг”-ийг 2021 оны 03 сарын 22-ны өдөөс 23-ны өдрүүдэд Бүрэгхангай суманд зохион байгуулж эрт илрүүлэг үзлэг зохион байгуулах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн томилолт шатахууны зардалд 186.9 мянган төгрөг зарцуулхаар шийдвэрлэж эрүүл мэндийн газрын мэргэжилтэн болон нэгдсэн эмнэлгийн эмч 5 албан хаагчдад томилолтын мөнгө 144.0 мянган төгрөг шатахууны зардалд 42.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Аймгийн онцгой комиссын даргын 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 10 тоот тушаалаар Сэлэнгэ суманд Коронавируст халдвар /Ковид 19/-т өвчин батлагдан, цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, илрүүлэх хариу арга хэмжээ авах, нөөц бүрдүүлэхэд эрүүл мэндийн байгууллагад түргэвчилсэн оношлуур худалдан авахад

